Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

# ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН САЛБАРЫН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ ГОМБО ОВОГТОЙ ТУУЛЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

## НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Эрүүл мэндийн байгууллагуудын санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд хийх санхүүгийн хяналт шалгалт, Улсын төсвийн хөрөнгөөр баригдаж байгаа барилга, их засварын гүйцэтгэл, тоног төхөөрөмжийн хангалт нийлүүлэлт, ашиглалтын дотоод аудит** | | | | | | | |
| 1. | Хууль бус шийдвэрийн улмаас төрийн албанаас халагдсан ажилтнуудад нөхөн олговрыг хуулийн дагуу буруутай этгээдээр төлүүлсэн эсэхэд гүйцэтгэлийн аудит хийх | Аудитын тайлан | - | Дүгнэлт, санал, зөвлөмж | Сайдын баталсан удирдамжийн дагуу Хууль бус шийдвэрийн улмаас төрийн албанаас халагдсан ажилтнуудад нөхөн олговрыг хуулийн дагуу буруутай этгээдээр төлүүлсэн эсэхэд гүйцэтгэлийн аудитыг хийж гүйцэтгэн Аймаг, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын дарга нарт 2025 оны 8/2815-8/2824 дугаар албан бичгийг цахимаар, мөн ЭМЯ-ны ТЗУГ-т №200 дугаар дотоод меморандум тус тус хүргүүлсэн.<br>Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргүүдийн төрд учирсан хохирол 877.0 сая төгрөг бөгөөд төрийн албанаас халагдсан ажилтнуудад нийт 781.1 сая төгрөгийг төрөөс хохирлыг барагдуулсан бол 63.4 сая төгрөгийг хууль бус шийдвэр | 03-05 сар | |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | гаргасан албан тушаалтнаар төлүүлсэн байна. | | |
| 2. | Арга хэмжээ 1.2.<br>Сонгосон төсөл хөтөлбөрийн хүрээнд хувиарлагдсан тоног төхөөрөмжийн хувиарлалт, хадгалалт хамгаалалтад дотоод аудит хийх | Аудитын тайлан | - | Дүгнэлт, санал, зөвлөмж дэвшүүлсэн байна. | ТНБД-ын 2025 оны А/32 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн буцалтгүй тусламжийн санхүүжилтээр 2024-2025 онд Эрүүл мэндийн яаманд нийлүүлэгдсэн эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг тушаалын дагуу эрүүл мэндийн байгууллагуудад олгосон эсэхэд дотоод аудит хийсэн.<br>2024-2025 онд ЭМС-ын 9 тушаалаар 5.5 тэрбум, ТНБД-ын 9 тушаалаар 2.6 тэрбум, нийт 8.1 тэрбум төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан бна.<br>Шалгалтаар илэрсэн зөрчил, зөвлөмж, тайланг Ажлын хэсгийн даргад хүргүүлсэн. | 04-05 сар | |
| 3. | Арга хэмжээ 1.3<br>Эрүүл мэндийн салбарын Улсын хөрөнгө оруултаар хэрэгжих төсөл арга хэмжээний гүйцэтгэлд дотоод аудит хийх | Аудитын тайлан | - | Дүгнэлт, санал, зөвлөмж дэвшүүлсэн байна. | Сайдын баталсан удирдамжийн дагуу Монгол Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа:<br>-Эрүүл мэндийн төвийн барилга /УБ. Чингэлтэй дүүрэг 4 хороо/,<br>-Эрт илрүүлэг, оношилгооны төвийн барилга /УБ. Чингэлтэй зүүрэг/,<br>-Улсын нэгдүгээр төв эмгэлгийн барилгын гадна засвар-ын гүйцэтгэлд | 06 сар | |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | дотоод аудит хийхээр Санхүү, эдийн засаг бодлогын газраас холбогдох материалыг /№207/ гаргуулан авч, шалгалтыг эхлүүлсэн. | | |
| **Зорилт 2. Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагаанд санүүгийн хяналт шалгалт** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 2.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг хийх | Аудитын тайлан | - | Дүгнэлт, санал, зөвлөмж дэвшүүлсэн байна. | Сайдын баталсан удирдамжийн дагуу Эрүүл мэндийн даатгалын сангийн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг хийж тайланг ЭМДЕГ-т 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 8/2915 дугаар албан бичгээр хүргүүлсэн | 04-05 сар | |
| **Зорилт 3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн явцын хяналтад дотоод аудит хийх** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 3.1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт тавих | Цахимд мэдээлэл байршуулсан байна. | - | Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлсэн байна | ЭМЯ-ны ажлын байрны үндсэн чиг үүрэг шинэчлэн батлагдсантай холбоотойгоор ТНБД-ын 2025 оны А/07 тушаалаар цахим хуудсанд мэдээлэл байршуулах журмыг шинэчилэн 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр батлуулсан.<br>Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2025 оны 1 дүгээр улирлын байдлаар яамны цахим хуудсанд нийт 113 мэдээлэл байршуулахаас 3 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан, 7 мэдээлэл цахим санд байршуулаагүй байсанд Санхүү, эдийн засаг, бодлогын газарт 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр №200 тоот меморандум хүргүүлсэн. | 1 дүгээр улирал | |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | ЭМЯ-ны цахим санд 1 дүгээр улирлын байдлаар 106 мэдээлэл байршуулсан байна. | | |
| **Зорилт 4. Үндэсний аудитын газраас Эрүүл мэндийн сайдын төсвийн багц, тусгай сан, хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн үйл ажиллагааны гүйцэтгэлд хийсэн аудитын зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтэд явцын хяналт, шалгалт.** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 4.1.<br>Үндэсний аудитын газраас 2020-2024 онд Эрүүл мэндийн салбарын санхүүгийн тайланд хийсэн аудитын зөвлөмж, акт албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавих | Зөвлөмжийн хэрэгжилт | - | Аудитын зөвлөмжийн биелэлтийг ҮАГ-т хүргүүлсэн байна. | Үндэсний аудитын газраас "Нийгмийн даатгалын тогтолцоо, түүний үр нөлөө"-д 2024 онд хийсэн гүйцэтгэлийн аудитын хүрээнд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт аудит хийж тус газрын мэдээллийн санд зөрүүтэй мэдээлэл бүртгэсэн зөрчил илэрсэнд ХШҮДАГ-аас хяналт шалгалтыг хийж тайланг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр ирүүлэх албан шаардлага хүргүүлсэн байна.<br>Албан шаардлагын дагуу хяналт шалгалтыг хийж тайланг 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 2/3010 дугаар албан бичгээр ҮАГ-т хүргүүлсэн.<br><br>Үндэсний аудитын газрын санхүүгийн тайлангийн аудитын системд "Санхүүгийн тайлангийн аудит"-аар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нэгтгэн 2025 оны 05 дугаар сарын байдлаар ЭЭХХЗГ, ГССҮТ, УНТЭ, УГТЭ, ХТС, ЭМЯ, Дэмжих сангийн мэдээллийг баталгаажуулан https://fas.audit.mn цахим санд бүртгүүлсэн. | 06 сар | |

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| | | | | | Мэдээллийг Үндэсний аудитын газрын аудитор Ц.Сугармаа хянаж баталгаажуулсан. | | |
| **Зорилт 5. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх** | | | | | | | |
| 1 | Арга хэмжээ 5.1. Эрүүл мэндийн байгууллагын 2024 оны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн үнэлгээ хийх | Үнэлгээний дүн | - | Дүнг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна. | Эрүүл мэндийн байгууллагуудын 2024 оны үйл ажиллагааны гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан. Хуваарийн дагуу Аймаг нийслэлийн ЭМГ-ын Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтэд үнэлгээг хийж тайланг ажлын хэсэгт хүргүүлсэн. ЭМЯ-ны харьяа байгууллагын ил тод шалгуур үзүүлэлтийн үнэлгээ 49.5 хувь, Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагын ил тод шалгуур үзүүлэлтийн үнэлгээ 52.7 хувь буюу “Эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлэгдсэн. | 02 дугаар сар | |

## ХОЁР. НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

| Д/д | Үүрэг даалгавар (арга хэмжээ) | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Үүрэг даалгавар (арга хэмжээ 1) Сэтгэцийн Эрүүл мэндийн үндэсний төвийн **2024 он**ы хэвтэн эмчлүүлэх тасгийн төлбөртэй тусламж үйлчилгээнд тусгайлсан хяналт шалгалт хийх | Аудитын тайлан | - | - | Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн 2024 оны 05/20168 дугаар албан бичиг, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс ирүүлсэн гомдол мэдээллийн дагуу тус төвийн **2024 оны** 01-10 дугаар сарын хэвтэн эмчлүүлэх тасгийн төлбөртэй тусламж үйлчилгээнд санхүүгийн хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн.<br>Хяналт шалгалтаар 124,591,000 төгрөгийн төлбөрийн зөрүү үүссэн тул гэмт хэргийн шинжтэй үйлдэл байж болзошгүй гэж үзэн Авлигатай тэмцэх газарт 2025 оны 01 дүгээр сарын 21-ний 8/330, Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газарт 2025 оны 01 дүгээр сарын 21-ний 8/329 албан бичгийг тус тус хүргүүлсэн.. | 01 сар | |
| 2 | Үүрэг даалгавар (арга хэмжээ 2) Сэтгэцийн Эрүүл мэндийн үндэсний төвийн **2022-2024** оны хэвтэн эмчлүүлэх тасгийн төлбөртэй тусламж үйлчилгээнд санхүүгийн хяналт, шалгалт хийж, шинжээчийн дүгнэлт гаргах. | Шинжээчийн дүгнэлт | - | Шинжээчийн дүгнэлтийг ЦЕГ-т хүргүүлсэн байна. | ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албаны 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 11/2217 албан бичгээр шинжээч томилж, шинжилгээ хийлгэх албан бичиг ирсэний дагуу Сэтгэцийн Эрүүл мэндийн үндэсний төвийн **2022-2024** оны хэвтэн эмчлүүлэх тасгийн төлбөртэй тусламж үйлчилгээнд хяналт шалгалтыг хийж шинжээчийн дүгнэлт гаргасан. | 02-03 сар | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Арга хэмжээ 1.<br><br>Дотоод аудитын сургалтад хамрагдах | - | - | Сургалтад хамрагдсан байна. | Сангийн яам, Баянгол дүүргийн Засаг даргын дэргэдэх Дотоод аудитын албанаас хамтран зохион байгуулсан “Дотоод аудитын үйл ажиллагааны стандарт, арга зүй” сэдэвт үзүүлэх сургалтад оролцсон. | 05 сар | |
| 2. | Арга хэмжээ 2.<br><br>Төрийн албан хаагчдад зориулсан сургалтанд хамрагдах | - | - | Сургалтад хамрагдсан байна. | Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас төрийн жинхэнэ албан хаагчдыг дотоод, гадаадад сургаж, хөгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хүрээнд Бүгд Найрамдах Энэтхэг Улсын “Техник, Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Хөтөлбөр (ITEC)”-өөс зохион байгуулах “Санхүүгийн удирдлага ба дотоод аудит” сэдэвт сургалтад Бүгд найрамдах Энэтхэг улсын Дэли хотноо 2025 ны 03 дугаар сарын 23-ны өдрөөс 04 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэл хугацаанд оролцсон. | 03-04 сар | |

ТАЙЛАН ГАРГАСАН:
ХШҮДАГ-ын шинжээч ................ / .Г.Туул / 2025.06.10
*(Албан тушаал)* *(Нэр, гарын үсэг)* *(Огноо)*